



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/95

Бор-Өндөр сум

**Эзэмшил газрын хэмжээг өөрчлөх  
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сум дахь иргэн, аж ахуйн нэгжийн газар эзэмших, өмчлөх эрхийн гэрчилгээ бүхий газарт 2016-2022 онд хяналтын хэмжилт хийгдсэнээр газар эзэмших, өмчлөх эрхийн гэрчилгээнд тусгагдсан газрын хэмжээ одоо байгаа хэмжээтэй зөрж байгаа тул хэмжээний зөрүү болон нэгж талбарын дугаар, Бор-Өндөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны 63 дугаар тогтоол, мөн 2018 оны 09 дүгээр тогтоолд тусгагдсан хаягаар гэрчилгээг шинэчлэн олгосугай.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан газар эзэмших эрхийн гэрчилгээг шинэчлэн олгож гэрээг байгуулан, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Эрдэнэзаяа)-д, гэрээнд заасан зориулалт, нөхцлийг хангаж ажиллан, гэрээг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ